



Н ГАЗАР

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3118,
Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com,
Цахим хуудас: www.govisumber.gov.mn

2024.04.18 № 01/450

танай _____ -ны № _____ -т

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ

Байгууллагын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлж ажиллана уу.

Хавсралт хуудастай.

**ҮЙЛ АЖИЛЛАГААНД
Й ТАЙЛАН**

ДАРГА

Д.СОДНОМ



*С. Энх-Аюуш
Баярмал
Тайлан, бүтээгдэхүүн
Бүтэц алтан
17/04/2024*

4287400666

5911 86 99 - Дорнод

ЧОЙР 2024 ОН

Говьсүмбэр аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж 88.73 хувь, Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 88.35 хувь, Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж 85.6 хувь, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт 88.78 хувь, ерөнхий үнэлгээ 87.9 хувь байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй 4 заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэгдсэн нийт 3 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн нийт 19 арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, 2024 оны төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх нь зүйтэй байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуульд заасан мэдээллийг ил тод, нээлттэй болгож, иргэдийг үнэн зөв, бүрэн, ойлгомжтой мэдээллээр хангах, мэдээллийн үйлчилгээг шуурхай, хялбар болгоход анхаарч, хуулийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үнэлгээний дүн

№	Үзүүлэлт	Үнэлгээ			
		Хувь	Жин	оноо	
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.	89.6	0.5	0.44
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.	90.0		
		3.Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт.	84.6		
		4.Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.	88.7		
		5.Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөө.	93.3		
		6.Шинэ сэргэлтийн бодлого.	80.0		
		7. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт	94.9		
		Дундаж	88.73		
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.	-	0.15	0.13
		2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	90.0		
		3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт.	85.0		
		4. Аймгийн Засаг даргаас төсвийн шууд захирагч нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт.	86.5		

		Зөвлөмжийн хэрэгжилт	92.9		
		Дундаж	88.35		
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ.	90.1	0.2	0.17
		2.Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ.	80.7		
		3.Шударга байдлын түвшин	86.0		
		-Авилгын эсрэг төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт			
		-Тушаал, шийдвэр.			
4.Хэрэглэгчийн үнэлгээ	-				
	Дундаж	85.6			
4	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт.	89.4	0.15	0.13
		-Ногоон байгууламж (Мод тарих)			
		-Цахим шилжилт			
		-Хог хаягдлын менежмент			
	2.Нээлттэй Говьсүмбэр	87.0			
	Дундаж	88.78			
Ерөнхий үнэлгээ				1.0	87.9

НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Говьсүмбэр аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дор дурдсан асуудалд анхаарал хандуулж, удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Зөвлөмж болгож байна.

Бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах талаар:

1. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээг үр дүнд чиглүүлж, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхой, оновчтой, үр дүнг илэрхийлэхүйц, хэмжих боломжтой байдлаар тодорхойлох;
2. Бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, түүний эх үүсвэрийг үндэслэл, тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх;

Бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар:

1. Бага, дунд боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх. - *М. Дамба*.
2. Боловсролын байгууллагын үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, ариун цэврийн өрөө, сургалтын танхимын стандартыг хангуулахад анхаарах. - *Оршгоо*.
3. Боловсролын салбарын багш, ажилчдын ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэхэд анхаарах. - *Мэргэжлийн*.
4. Шинжлэх ухаан, инновацийг хөгжүүлэх чиглэлээр бодлого, төлөвлөлтийг сайжруулж, салбар хоорондын уялдааг хангах. - *М. Дамба*
- *Мэргэжлийн*.
5. Хэлний бодлогын зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, эрчимжүүлэх. - *Солонгос*.
6. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах. - *Лосов*.